

БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: БӨА-2023/01/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас: [www.audit.mn](http://www.audit.mn)  
Өлгий хот  
2023 он

Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,  
тэргүүлэх аудитор: М.Хуанган  
Утас: 70422954 Цахим хаяг: khuanganm@audit.gov.mn  
Аудитын менежер: Х.Женисбек  
Утас: 70422930 Цахим хаяг: jenisbekh@audit.gov.mn  
Ахлах аудитор: С.Нурлан  
Утас: 88403281 Цахим хаяг: nurlans@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу. .

## **АГУУЛГА**

---

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....	3
Асуудлыг онцолсон хэсэг .....	<b>Error! Bookmark not defined.</b>
Аудитын гол асуудал.....	<b>Error! Bookmark not defined.</b>
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА .....	<b>Error! Bookmark not defined.</b>
4. АУДИТЫН ТАЙЛАН .....	14
4.1 Ерөнхий зүйл.....	14
4.2 Материаллаг байдал.....	15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт .....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал.....	15
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт.....	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт .....	16
4.5.1 Завсрын аудитын талаар.....	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал .....	16
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ .....	16
5.1 Төлбөрийн акт .....	16
5.2 Албан шаардлага .....	16
5.3 Зөвлөмж.....	17
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ .....	17

### **Товчилсон үгийн жагсаалт**

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын стандарт

## 1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



### БАЯН-ӨЛГИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

83129 Өлгий, Баян-Өлгий аймаг,  
Утас/Факс: (976) 7042-2954  
E-mail: bayanulgii@audit.gov.mn

АЙМГИЙН ИРГЭДИЙН  
ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН НАРИЙН  
БИЧГИЙН ДАРГА А.СЕРИКБОЛАТ ТАНАА

2023.02.24 № 210  
танай \_\_\_\_\_-ны № \_\_\_\_\_-т

#### Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

#### Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

#### Асуудлыг онцолсон хэсэг

2022 оны санхүүгийн тайлантай холбоотой онцлог асуудал байхгүй байна.

#### Аудитын гол асуудал

2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд анхаарал татах асуудал байхгүй.

#### Бусад асуудлын хэсэг

Аудит, аудиторын хариуцлага, аудитын тайлангийн тухай хэрэглэгчдэд хамаатай бөгөөд санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй.

#### Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  М.ХУАНГАН



## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
<b>1</b>	<b>ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>10015083.56</u></b>	<b><u>7335551.00</u></b>
<b>33</b>	<b>АВЛАГА</b>	2679532.56	0.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2679532.56	0.00
<b>35</b>	<b>БАРАА МАТЕРИАЛ</b>	7335551.00	7335551.00
<b>354</b>	<b>Хангамжийн материал</b>	7335551.00	7335551.00
35410	Бичиг хэргийн материал	5100.00	5100.00
35420	Аж ахуйн материал	7330451.00	7330451.00
<b>2</b>	<b>ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН</b>	<b><u>13136709.63</u></b>	<b><u>15807087.12</u></b>
<b>39</b>	<b>ҮНДСЭН ХӨРӨНГӨ</b>	13136709.63	15807087.12
<b>392</b>	<b>Биет хөрөнгө</b>	13017959.63	15763337.12
39201	Барилга, байгууламж, орон сууц	3837203.28	3837203.28
39202	Хуримтлагдсан элэгдэл	-767440.80	-1023254.40
39203	Авто-тээврийн хэрэгсэл	180000000.00	180000000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-180000000.00	-180000000.00
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	25160250.00	31310250.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-20137404.08	-21931445.64
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	29009895.00	29304895.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-24084543.77	-25734311.12
<b>393</b>	<b>Биет бус хөрөнгө</b>	118750.00	43750.00
39301	Програм хангамж	850000.00	850000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-731250.00	-806250.00
39303	Бусад биет бус хөрөнгө	500000.00	500000.00
39304	Хуримтлагдсан элэгдэл	-500000.00	-500000.00
<b>3</b>	<b>НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II</b>	<b><u>23151793.19</u></b>	<b><u>23142638.12</u></b>
<b>5</b>	<b>ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН</b>	<b><u>23151793.19</u></b>	<b><u>23142638.12</u></b>
<b>51</b>	<b>Засгийн газрын хувь оролцоо</b>	23151793.19	23142638.12
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	158734618.96	158734618.96
51102	- хувийн	158734618.96	158734618.96
<b>512</b>	<b>Хуримтлагдсан үр дүн</b>	-145148514.17	-145157669.24
51210	Өмнөх үеийн үр дүн	-135739252.41	-145148514.17
51220	Тайлант үеийн үр дүн	-9409261.76	-9155.07
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	9565688.40	9565688.40
<b>6</b>	<b>ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V</b>	<b><u>23151793.19</u></b>	<b><u>23142638.12</u></b>

### 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Төгрөгөөр

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)</b>	<b>541,275,900.00</b>	<b>1,310,238,300.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>541,275,900.00</b>	<b>1,310,238,300.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	149,960,000.00	769,052,500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	136,130,000.00	769,052,500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13,830,000.00	
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	391,315,900.00	541,185,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	391,315,900.00	541,185,800.00
<b>2</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН</b>	<b>550,685,161.76</b>	<b>1,310,247,455.07</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>550,685,161.76</b>	<b>1,310,247,455.07</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	499,306,278.72	1,305,209,411.13
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	155,851,731.49	162,100,646.81
210101	Үндсэн цалин	119,532,260.47	128,345,437.53
210102	Нэмэгдэл	33,610,471.02	31,364,909.28
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,709,000.00	2,390,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	18,901,796.42	19,774,198.81
210201	Тэтгэврийн даатгал	13,666,921.59	14,030,407.80
210202	Тэтгэмжийн даатгал	1,394,368.31	1,269,855.23
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,115,734.53	1,119,730.39
210204	Ажилгүйдлийн даатгал	247,733.90	305,155.25
210205	Эрүүл мэндийн даатгал	2,477,038.09	3,049,050.14
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28,723,884.26	26,086,943.00
210401	Бичиг хэрэг	1,448,998.00	723,000.00
210402	Тээвэр, шатахуун	25,000,000.00	22,811,600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,274,886.26	2,552,343.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	710,000.00	710,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	710,000.00	710,000.00

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7,768,050.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	7,768,050.00	10,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9,981,600.00	7,878,800.00
210702	Дотоод албан томилолт	9,981,600.00	7,878,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,545,337.00	2,562,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	142,937.00	2,562,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180,000.00	
210803	Даатгалын үйлчилгээ	1,600,000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	190,000.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44,000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	388,400.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	274,823,879.55	1,076,096,322.51
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	255,996,747.66	1,067,240,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,166,350.00	5,081,700.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	13,660,781.89	3,774,622.51
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	51,378,883.04	5,038,043.94
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	51,042,100.00	1,666,700.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49,375,400.00	-
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,666,700.00	1,666,700.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	336,783.04	3,371,343.94
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	336,783.04	3,371,343.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)</b>	<b><u>(9,409,261.76)</u></b>	<b><u>(9,155.07)</u></b>
<b>5</b>	<b>НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)</b>	<b><u>(9,409,261.76)</u></b>	<b><u>(9,155.07)</u></b>

**2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан**

**Төгрөгөөр**

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
<b>1</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)</b>	<b>541275900.00</b>	<b>1310238300.00</b>
<b>13</b>	<b>ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО</b>	<b>541275900.00</b>	<b>1310238300.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	149960000.00	769052500.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	136130000.00	769052500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13830000.00	
131106	Төсвийн урамшуулал		
<b>1320</b>	<b>Орон нутгийн төсвөөс санхүүжих</b>	391315900.00	541185800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	391315900.00	541185800.00
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)</b>	<b>539337951.96</b>	<b>1303793300.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>539337951.96</b>	<b>1303793300.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	<b>487959068.92</b>	<b>1298755256.06</b>
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	156528500.00	161052817.83
210101	Үндсэн цалин	119161200.00	125844755.66
210102	Нэмэгдэл	34658300.00	32817762.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2709000.00	2390300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	20533500.00	18142495.23
210201	Тэтгэврийн даатгал	14272300.00	13294568.74
210202	Тэтгэмжийн даатгал	1565300.00	1229381.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1252200.00	983264.92
210204	Ажилгүйдлийн даатгал	313100.00	239789.15
210205	Эрүүл мэндийн даатгал	3130600.00	2395491.23
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	28720984.26	26086943.00
210401	Бичиг хэрэг	1446098.00	723000.00
210402	Тээвэр, шатахуун	25000000.00	22811600.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2274886.26	2552343.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	710000.00	710000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	710000.00	710000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	7768050.00	10000000.00
210604	Урсгал засвар	7768050.00	10000000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	9981600.00	7878800.00
210702	Дотоод албан томилолт	9981600.00	7878800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2545337.00	2562500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	142937.00	2562500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	180000.00	

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

210803	Даатгалын үйлчилгээ	1600000.00	
210804	Тээврийн хэрэгслийн татвар	190000.00	
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	44000.00	
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	388400.00	
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	<b>261171097.66</b>	<b>1072321700.00</b>
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	256004747.66	1067240000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5166350.00	5081700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	<b>51378883.04</b>	<b>5038043.94</b>
<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	<b>51042100.00</b>	<b>1666700.00</b>
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	49375400.00	0.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1666700.00	1666700.00
<b>2134</b>	<b>Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт</b>	<b>336783.04</b>	<b>3371343.94</b>
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	336783.04	3371343.94
<b>3</b>	<b>ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)</b>	<b><u>1937948.04</u></b>	<b><u>6445000.00</u></b>
<b>5</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)</b>	<b><u>1946950.00</u></b>	<b><u>6445000.00</u></b>
<b>22</b>	<b>ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ</b>	<b><u>1946950.00</u></b>	<b><u>6445000.00</u></b>
<b>2200</b>	<b>Дотоод эх үүсвэрээр</b>	<b>1946950.00</b>	<b>6445000.00</b>
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	1946950.00	6445000.00
<b>6</b>	<b>ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)</b>	<b><u>-1946950.00</u></b>	<b><u>-6445000.00</u></b>
<b>8</b>	<b>НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)</b>	<b>-9001.96</b>	<b>0.00</b>
<b>9</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>9001.96</b>	<b>0.00</b>
<b>10</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>0.00</b>	<b>0.00</b>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Төгрөгөөр

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2019 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	158,734,618.96	9,565,688.40	-135,739,252.41	32,561,054.95
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>158,734,618.96</b>	<b>9,565,688.40</b>	<b>-135,739,252.41</b>	32,561,054.95
C07	Тайлант үеийн үр дүн			-9,409,261.76	-9,409,261.76
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>158,734,618.96</b>	<b>9,565,688.40</b>	<b>-145,148,514.17</b>	23,151,793.19
D01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	<b>158,734,618.96</b>	<b>9,565,688.40</b>	<b>-145,148,514.17</b>	23,151,793.19
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт			0.00	0.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	<b>158,734,618.96</b>	<b>9,565,688.40</b>	<b>-145,148,514.17</b>	23,151,793.19

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

D08	Тайлант үеийн үр дүн			-9,155.07	-9,155.07
D09	<b>2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл</b>	<b>158,734,618.96</b>	<b>9,565,688.40</b>	<b>-145,157,669.24</b>	23,142,638.12

**2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**Төгрөгөөр**

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
<b>1</b>	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>2</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>541,185,800.00</b>	<b>537,814,456.06</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	541,185,800.00	537,814,456.06
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	539,519,100.00	536,147,756.06
<b>2101</b>	<b>Цалин хөлс болон нэмэгдэл урамшил</b>	161,105,900.00	161,052,817.83
210101	Үндсэн цалин	125,344,200.00	125,844,755.66
210102	Нэмэгдэл	33,052,700.00	32,817,762.17
210103	Унаа хоолны хөнгөлөлт	2,709,000.00	2,390,300.00
<b>2102</b>	<b>Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл</b>	18,888,300.00	18,142,495.23
210201	Тэтгэврийн даатгал	13,475,100.00	13,294,568.74
210202	Тэтгэмжийн даатгал	1,353,300.00	1,229,381.19
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,082,600.00	983,264.92
210204	Ажилгүйдлийн даатгал	270,700.00	239,789.15
210205	Эрүүл мэндийн даатгал	2,706,600.00	2,395,491.23
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	25,156,700.00	25,134,443.00
210401	Бичиг хэрэг	723,000.00	723,000.00
210402	Тээвэр, шатахуун	21,880,500.00	21,859,100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	2,553,200.00	2,552,343.00
<b>2105</b>	<b>Нормативт зардал</b>	710,000.00	710,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	710,000.00	710,000.00
<b>2106</b>	<b>Эд хогшил, урсгал засварын зардал</b>	10,000,000.00	10,000,000.00
210604	Урсгал засвар	10,000,000.00	10,000,000.00
<b>2107</b>	<b>Томилолт, зочны зардал</b>	7,929,000.00	7,878,800.00
210702	Дотоод албан томилолт	7,929,000.00	7,878,800.00
<b>2108</b>	<b>Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж</b>	2,562,500.00	2,562,500.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,562,500.00	2,562,500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	313,166,700.00	310,666,700.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	308,000,000.00	305,500,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	5,166,700.00	5,166,700.00
<b>213</b>	<b>УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ</b>	1,666,700.00	1,666,700.00

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

<b>2132</b>	<b>Бусад урсгал шилжүүлэг</b>	1,666,700.00	1,666,700.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,666,700.00	1,666,700.00
<b>13</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>541,185,800.00</b>	<b>537,814,456.06</b>
<b>1320</b>	<b>ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ</b>	541,185,800.00	537,814,456.06
132001	Орон нутгийн төсвөөс	541,185,800.00	537,814,456.06
<b>62</b>	<b>АЖИЛЛАГСДЫН ТОО</b>	7.00	13.00
620001	Удирдах ажилтан	2.00	2.00
620002	Гүйцэтгэх ажилтан	5.00	11.00
<b>65</b>	<b>ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ</b>	<b>13.00</b>	<b>13.00</b>
650001	Төрийн захиргааны албан хаагч (ТЗ)	3.00	3.00
650009	Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ)	9.00	9.00
650011	Улс төрийн албан хаагч (УТ)	1.00	1.00

## 2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх он	Гүйцэтгэл
	<b>Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>		
<b>I</b>	<b>НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН</b>	<b>149959180.00</b>	<b>769052500.00</b>
<b>21</b>	<b>УРСГАЛ ЗАРДАЛ</b>	<b>149959180.00</b>	<b>769052500.00</b>
<b>210</b>	<b>БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ</b>	149959180.00	769052500.00
<b>2104</b>	<b>Хангамж, бараа материалын зардал</b>	0.00	952500.00
210402	Тээвэр, шатахуун		952500.00
<b>2109</b>	<b>Бараа үйлчилгээний бусад зардал</b>	149959180.00	768100000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	149959180.00	768100000.00
<b>2133</b>	<b>Олгосон санхүүжилт, шилжүүлэг</b>	<b>820.00</b>	<b>0.00</b>
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	820.00	0.00
<b>II</b>	<b>ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР</b>	<b>149960000.00</b>	<b>769052500.00</b>
<b>1311</b>	<b>Нэмэлт санхүүжилтийн орлого</b>	<b>149960000.00</b>	<b>769052500.00</b>
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	136130000.00	769052500.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	13830000.00	

### **3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА**

---

#### **3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа**

##### **Байгууллагын үйл ажиллагааны чиглэл, зорилго, зорилтын талаар**

Байгууллагын зорилго, зорилт, үйл ажиллагааны чиглэл: Баян-Өлгий аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Монгол Улсын Үндсэн хууль Засаг Захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжоор олгогдсон чиг үүргийг хэрэгжүүлж Нутгийн өөрөө удирдах ёсны байгууллагын чадавхыг дээшлүүлэн иргэдийн төлөөллөөрөө дамжуулан нутаг дэвсгэрийнхээ иргэдийнхээ эрх ашгийг хамгаалах чиг үүргийг хэрэгжүүлэх байгууллага юм.

#### **3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин**

##### **Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчны талаар**

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль болон бусад хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа мөрдөж ажилласан байна.

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлт ороогүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөгүй байна.

Байгууллагын хөтөлбөл зохих нягтлан бодох бүртгэлийг холбогдох заавар журмын дагуу хөтөлж, бараа материалын тайланг гаргаж, цалингийн цэсэд хавсаргах холбогдох тушаал, шийдвэр болон санхүүгийн анхан шатны баримтуудыг зохих журмаар бүрдүүлсэн байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 онд шалгалтад хамрагдаагүй тул дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

#### **3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал**

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

##### **Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар**

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж санхүү, бүртгэл, тайлагналын үйл ажиллагаандаа ажиллаагүй тул аудитаар зөвлөмж өглөө.

#### **3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд**

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 9.2 сая төгрөгөөр буюу 3.9 хувиар буурсан байна.

**Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт**

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0	0	0
Авлага	2,679.5	0	-2,679.5
Урьдчилж гарсан зардал	0	0	0
Бараа материал	7,335.5	7,335.5	0
Үндсэн хөрөнгө	13,136.7	15,807.1	2,670.4
<b>Нийт хөрөнгө</b>	<b>23,151.8</b>	<b>23,142.6</b>	<b>-9.2</b>
Өр төлбөр	0	0	0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	23,151.8	23,142.6	-9.2
<b>Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн</b>	<b>23,151.8</b>	<b>23,142.6</b>	<b>-9.2</b>

Дээрх хүснэгтээс харахад авлага, үндсэн хөрөнгийн дансанд нөлөө бүхий өөрчлөлт гарсан байна.

Авлага 2.7 сая төгрөгөөр буурсан нь өмнө оны авлагыг барагдуулсантай холбоотой.

Үндсэн хөрөнгийн данс 2.6 сая төгрөгөөр нэмэгдсэн нь төсвийн хөрөнгөөр 6.4 сая төгрөгийн хөрөнгө худалдан авч үндсэн хөрөнгөд 3.8 сая төгрөгийн элэгдэл байгуулсантай холбоотой.

Тайлант оны үр дүнгээр Засгийн газрын хувь оролцоо данс 9.2 сая төгрөгөөр буурсан байна.

**3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв**

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

**3.5.1 Төсвийн төлөвлөлт**

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 797.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 797.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Дээд шатны төсвийн захирагчаас төсвийн төслийг хянаж, төсвийн төслийн саналаас улсын төсвийн цалин хөлс болон нэмэгдэл урамшлыг 5.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 2.1 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардлыг 31.4 сая төгрөгөөр, норматив зардлыг 0.3 сая төгрөгөөр, эд хогшил, урсгал засварын зардлыг 18.6 сая төгрөгөөр, томилолт, зочны зардлыг 14.5 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж 5.0 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 182.2 сая төгрөгөөр, урсгал шилжүүлгийн зардлыг 8.3 сая төгрөгөөр нийт 256.7 сая төгрөгөөр бууруулж, 541.2 сая төгрөгөөр баталсан байна.

**3.5.2 Төсвийн гүйцэтгэл**

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Тайлант оны батлагдсан төсвийг 256.7 сая төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 541.2 сая төгрөгийг орон нутгийн төсвөөс бүрдүүлэхээр тусгасан байна.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 541.2 сая төгрөгийн санхүүжилтийг хүлээн авсан байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 537.8 сая төгрөг буюу 92.1 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлын төсвийг 3.4 сая төгрөгөөр дутуу зарцуулж, жилийн эцэст 3.4 сая төгрөгийг төвлөрүүлэн шилжүүлсэн байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	<b>Орон нутгийн өөрөө удирдах ёсны байгууллага-70101</b>	<b>541,185.8</b>	<b>537,814.4</b>	<b>3,371.4</b>	<b>92.1%</b>
1.1	Үндсэн үйл ажиллагааны зардал-80101	426,519.1	423,147.7	3,371.4	92.1%
1.2	Сургалт семинар-80312	15,000.0	15,000.0	0	100%
1.3	Ажил олгогчоос олгох тэтгэмж-80802	1,666.7	1,666.7	0	100%
1.4	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх-82201	98,000.0	98,000.0	0	100%
	<b>Дүн</b>	<b>541,185.8</b>	<b>537,814.4</b>	<b>3,371.4</b>	<b>92.1%</b>

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 онд 769.0 сая төгрөгийн нэмэлт санхүүжилт авч гүйцэтгэлээр 100 хувь зарцуулсан байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 онд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

## 4. АУДИТЫН ТАЙЛАН

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулах хууль тогтоомжийн хэрэгжилт, бүртгэл тайлагналтай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитыг Баян-Өлгий аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор С.Нурлан гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Х.Женисбек, дарга, тэргүүлэх аудитор М.Хуанган нар тус тус хэрэгжүүлсэн.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал нь 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 24-ны өдрийн 01/24 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

#### **4.2 Материаллаг байдал**

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагын 550.7 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 8.3 сая төгрөгөөр, тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

#### **4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт**

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор цалин хөлс болон нэмэгдэл урамшил 0.05 сая төгрөгөөр, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 0.7 сая төгрөгөөр, хангамж, бараа материалын зардал, томилот, зочны зардлыг 0.07 сая төгрөгөөр, бараа үйлчилгээний бусад зардлыг 2.5 сая төгрөгөөр нийтдээ 3.4 сая төгрөгийг хэмнэж ажилласан байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилтийг шалгахад “Төрийн хэмнэлтийн тухай хууль”-ийн хэрэгжилтийг хангаж ажилласан ба алдаа, зөрчил илрээгүй.

#### **4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

##### **4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт**

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор [www.shilendans.gov.mn](http://www.shilendans.gov.mn) цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны мэдээллээс шалгах программд орсон мэдээллүүдийн хэрэгжилтийг шалгав. Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 35.3 сая төгрөгийн 12 удаагийн шийдвэрийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдал 75 хувьтай байгаа зөрчилд зөрчил арилгуулах албан шаардлага өгөв.

Шийдвэрлэсэн нь: Аудитын дүнгээр шилэн дансны зөрлийг арилгуулах албан шаардлага өгөгдлөө.

Тус байгууллагын 2022 оны шилэн дансны үйл ажиллагаанд Төрийн аудитын газраас хяналт шалгалт хийгдсэн.

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд үйл ажиллагааг явуулсан байна.

#### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

##### 4.5.1 Завсрын аудитын талаар

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд завсрын аудит хийгдсэн ба завсрын аудитаар зөрчил илрээгүй.

##### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх 2021 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмж албан шаардлагын хэрэгжилтийг шалгаж үзэхэд 2021 онд нийт 44.4 сая төгрөгийн зардлыг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан зөрчилд өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлээгүй байна.

Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 188.9 сая төгрөгийн мөнгөн гүйлгээ, авлага үүсгэсэн 2.6 сая төгрөгийн шийдвэрийг мэдээлээгүй зөрчилд өгсөн албан шаардлагыг хэгжүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	1	1,411.3	1	1,411.3	100%
Албан шаардлага	2	197,187.8	2	197,187.8	100%
Зөвлөмж	1	44,372.9			
<b>Нийт дүн</b>	<b>4</b>	<b>242,972.0</b>	<b>3</b>	<b>198,598.8</b>	<b>81.7%</b>

#### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах зүйл байхгүй.

### 5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар залруулга хийгдээгүй. Хууль хяналтын байгууллагад албан шаардлагаар шилжүүлсэн, хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлсэн асуудал байхгүй.

Аудитаар нийт 111.6 сая төгрөгийн зөрчил<sup>1</sup> илэрснээс, 111.6 сая төгрөгийн зөрчилд албан шаардлага хүргүүлж, 0 сая төгрөгийн зөрчилд зөвлөмж өгсөн.

#### 5.1 Төлбөрийн акт

Төлбөрийн акт байхгүй.

#### 5.2 Албан шаардлага

Аудитаар дараах зөрчилд албан шаардлага өгөгдлөө. Үүнд:

<sup>1</sup> Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

1. Шилэн дансанд төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 35.3 сая төгрөгийн 12 удаагийн шийдвэрийн мөнгөн гүйлгээг мэдээлээгүй, шилэн дансанд мэдээлсэн байдал 75 хувьтай байна.

2. Төлөөлөгчдийн үйл ажиллагааны зардал, томилолт, замын зардал, хоолны үнэ, шатахууны үнэ, интернэтийн төлбөр, ярааны төлбөр, бичиг хэргийн үнэ, сургалтын төлбөр, бусад байгууллагуудад олгосон гэмт хэргээс урьдчилан сэргээлгэх ажлын зардал болон бусад материалын зардлуудын нийт 76.3 сая төгрөгийн гүйлгээг тооцооны данс дамжуулахгүйгээр шууд зардлаар бүртгэж тайлагнасан.

### 5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

#### 1.1. Илрүүлэлт:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиггүй байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.9-д "нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг" гэж бүртгэлийн суурь, санхүүгийн тайлан гаргахад баримтлах зарчмыг тодорхойлсон журам, заавар, аргачлалыг багтаасан баримт бичгийг", 18 дугаар зүйлийн 18.2-т "Аж ахуйн нэгж, байгууллагын удирдлага нь нягтлан бодох бүртгэлийн хууль тогтоомж, стандарт, дүрэм, журам, зааварт нийцүүлэн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг баталж, мөрдөж ажиллана" гэсэн заалттай нийцээгүй байна.

#### 1.2. Өгсөн зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн хэрэгжилтийн хангаж нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж санхүү, бүртгэл, тайлагналын үйл ажиллагаандаа ашиглах, байгууллагын удирдлага, нягтлан бодогч нар санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаарх мэдээлэл, ойлголтоо сайжруулах;

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2022 оны 10 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

## 6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/				Зөвлөмж	
							Үүнээс					
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
<b>Дүн</b>												

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

**Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллага Д шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Нийт 76.3 сая төгрөгийн гүйлгээг шууд зардлаар бүртгэж тайлагнасан	2	76,333.5			1	76,333.5	1	0,0				
<b>Дүн</b>	<b>2</b>	<b>76,333.5</b>			<b>1</b>	<b>76,333.5</b>	<b>1</b>	<b>0,0</b>				

**Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал**

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах тухай 35.3 сая төгрөгийн 12 удаагийн шийдвэрийг мэдээлээгүй	1	35,302.2			1	35,302.2		
<b>Дүн</b>	<b>1</b>	<b>35,302.2</b>			<b>1</b>	<b>35,302.2</b>		
Төрийн хэмнэлтийн тухай хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
<b>Дүн</b>								
<b>Нийт дүн</b>	<b>1</b>	<b>35,302.2</b>			<b>1</b>	<b>35,302.2</b>		